STUDIA ARCHAEOLOGICA
institute of Archaeology, Mongolia Academy of Sciences
DOI: https://doi.org/10.5564/sa.v45i2.3781

Tomus XLV 2024 Fasciculis 2

Энэбишийн Донойдугар[1]✉, Даваахүүгийн Одсүрэн[1, 2], Цэдэндоржийн Болорбат[2]

[1] Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Түүхийн тэнхим.
Монгол Улс, Улаанбаатар-210648, Бага тойруу - 14, Хичээлийн II байр
[2] Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн.
Монгол Улс, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Тал хээрийн палеолитын дурсгалын анхдагч цуулалтын асуудал

Хураангуй. Хэрлэн голоос урагш нам өндөртэй уулс, тэгш тал зонхилсон хээрийн бүс нутагт өнгөрсөн хугацаанд палеолитын судалгаа харьцангуй бага хийжээ. Тиймээс тус өгүүлэлд Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрээс сүүлийн жилүүдэд илрүүлсэн Ачаат уул, Богд уул, Зараа уулын Оцон цохио, Зүүн шовхын палеолитын суурины чулуун зэвсэг үйлдвэрлэлийн анхдагч цуулалтын арга ажиллагааны тухай өгүүлэв. Дээрх дурсгалууд нь дунд палеолитын төгсгөл, дээд палеолитын эхэн болон дунд үед холбогдоно. Чулуун зэвсэг үйлдвэрлэлийн анхдагч цуулалтын арга ажиллагаа нь төв рүү чиглэсэн, леваллуагийн, зэрэгцээ цуулалтын арга зонхилж байжээ. Леваллуагийн цуулалтын арга харьцангуй хожуу буюу дээд палеолитын дунд үе хүртэл ашиглагдаж байсан нь бүс нутгийн палеолитын соёлын бүсчлэлтэй холбоотой байх магадлалтай ажээ.

Түлхүүр үг: Цуулалтын арга, леваллуа, зэрэгцээ цуулалт, бэлдэц, үлдэц

Enebish Donoidugar[1]✉, Davaakhuu Odsuren[2], Tsedendorj Bolorbat[2]

Department of History, Mongolian National University of Education.
Mongolian National University of Education Building- II.
Baga toiruu – 14, Ulaanbaatar-210648, Mongolia
[2] Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-I.
Peace Avenue. Ulaanbaatar-13330, Mongolia

The Problem of primary knapping technique in Steppe Paleolithic sites

Abstract. In the region east of the Kherlen River, characterized by low mountains and vast plains, relatively little Paleolithic research has been conducted in recent times. Therefore, this article examines the primary flaking techniques used in the production of stone tools at the Paleolithic sites discovered in recent years in the territory of Sukhbaatar province, specifically at Achaat Mountain, Bogd Mountain, and the Otson Tsohio and Zuun Shovkh sites. These sites are associated with the final stage of the Middle Paleolithic and the Early and Middle Upper Paleolithic. The primary flaking techniques used in stone tool production were directed toward the center, with Levallois and parallel flaking methods predominating. The Levallois flaking technique was

© Э. Донойдугар, Д.Одсүрэн, Ц.Болорбат 2024
Email: dugaraado@gmail.com, https://orcid.org/0000-0002-4508-2295

used relatively late, continuing until the Middle Upper Paleolithic, likely in relation to the regional Paleolithic cultural zonation.

Keywords: *Knapping, Levallois, parallel flaking, preform, core*

Удиртгал

Манай орны нутаг дэвсгэрийн үлэмж хэсгийг бэсрэг уулс, тэгш тал зонхилсон хээрийн бүс эзэлнэ. Өнгөрсөн хугацаанд хээрийн бүс нутагт, тодруулбал Хэрлэн голоос урагшаа газар нутагт палеолитын дурсгалын судалгаа бусад газартай харьцуулахад тун цөөн хийгдсэн байдаг. Хэдийгээр ахмад судлаачдын тайланд газрын хөрсөн дээрээс палеолитын үед хамаарах цөөн тооны олдвор түүвэрлэж цуглуулсан тухай цухас дурдсан зүйл байх боловч он цаг, үйлдвэрлэлийн аргыг тэмдэглээгүй байна [Дорж, Цэвээндорж, 1978: 17-18]. Судлаачид монголын чулуун зэвсгийн үе, ялангуяа палеолитын судалгааг бүсчилсэн маягаар гүйцэтгэж байсан нь тухайн бүс нутагт энэ үеийг гүнзгийрүүлэн судлалгүй орхисон хамгийн том шалтгаан байжээ.

Сүүлийн жилүүдэд тал, хээрийн бүс нутгийн археологийн судалгаа эрчимжихийн хэрээр хуучин чулуун зэвсгийн судалгаанд зарим ахиц гарсан байна. 2004-2008 онд МУИС-аас зохион байгуулсан "Дорнод Монгол" төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг, Ачаат уулаас палеолитын олдвор түүвэрлэн цуглуулсныг судлаач Х.Пүрэвжал боловсруулж, харьцуулсан судалгааны үндсэн дээр мустьен төгсгөл үеэс дээд палеолитын эхэн үед холбогдуулан үзсэн байна [Цогтбаатар, Пүрэвжал, 2014: 19]. 2018 онд Монгол-Канадын хамтарсан "Говь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа" төслийн судлаачид Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт орших Зараа уулын Оцон цохио, Зүүн шовх зэрэг газраас дээд палеолитын үеийн дурсгалыг илрүүлж, малтан шинжилжээ. Оцон цохио, Зүүн шовхын дурсгалт газарт хийсэн малтлага судалгааны үр дүнд олон төрлийн амьтны яс, гоёл чимэглэлийн зүйлийг чулуун зэвсгийн баялаг олдворын хамт агуулсан соёлт давхаргатай дурсгал болохыг тогтоожээ. Мөн чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга ажиллагаа хийгээд үнэмлэхүй он цаг нь 34-24 мянган жилийн өмнөх үед хамаарахыг тогтоосон байна [Odsuren et al., 2020: 10].

2019 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судалгааны баг Сүхбаатар аймгийн Уулбаян сумын нутагт хайгуул судалгаа хийж Богд уул, Гурван овоот, Хангай хад зэрэг газраас хөрсөн дээр палеолитын хэв шинж бүхий олдвор агуулсан бууц сууриныг шинээр илрүүлжээ. Судлаачид эдгээр газраас цөөн олдвор түүвэрлэж, он цаг нь тогтоогдсон дурсгалуудтай харьцуулан дээд палеолитын эхэн, дунд, хожуу үед хамаатуулсан байна [Болорбат, Одсүрэн, 2021: 17; Болорбат нар., 2022: 16-17]

Сүүлийн үеийн судалгааны байдлаас үзэхэд тал, хээрийн бүс нутагт дунд палеолитын төгсгөл, дээд палеолитын үеийн соёлт давхаргатай болон ил бууц суурин олноор олдох магадлалтай бөгөөд бид энэ өгүүлэлд Богд уул, Ачаат уул, Зараа уулын Оцон цохио болон Зүүн шовхын палеолитын суурины хуучин чулуун зэвсгийн олдворын анхдагч цуулалтын арга ажиллагааны тухай авч үзэв.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй

Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Ачаат уул [Цогтбаатар, Пүрэвжал, 2014: 15-24], Уулбаян сумын Богд уул, Хангай хад, Гурван овоот (Болорбат, Одсүрэн, 2021: 13-16; Болорбат нар., 2022: 13-15), Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Зараа уулын Оцон цохио, Зүүн шовх [Odsuren et al., 2020: 1-41]-ын палеолитын дурсгалаас түүвэрлэн цуглуулсан болон малтлага судалгааны явцад илрүүлж баримтжуулсан чулуун зэвсгийн олдвор, тэр дундаа анхдагч цуулалтыг илэрхийлэх эдлэлүүд нь өгүүлэл бичих үндсэн хэрэглэгдэхүүн юм. Судалгааны хүрээнд авч үзэж буй ихэнх дурсгал ил суурин тул цуулалтын арга, холбогдох он цагийн асуудлыг тодруулахад Монгол хийгээд бусад бүс нутгийн судалгааны эргэлтэд орсон дурсгалыг харьцуулах хэрэглэгдэхүүн болгон ашиглав.

Чулуун зэвсгийн бууц суурины олдворыг анхдагч цуулалт, хоёрдогч боловсруулалт буюу ирлэлт, цуулдасны үйлдвэрлэл хэмээн ангилах төрөл зүйн ангиллын дагуу ялгаж, анхдагч цуулалтыг илэрхийлэх үлдцийн төрлийн

эдлэлийн тоон үзүүлэлтийг гаргав. Чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн арга, холбогдох он цагийн асуудлыг харьцуулалтын аргаар жишин тодруулав.

Палеолитын дурсгалын байршил, олдворын анхдагч цуулалтын ангилал

Саяхныг хүртэл тал, хээрийн бүс нутгийн палеолитын дурсгалын орших орчны мэдээлэл хомс байв. Харин сүүлийн жилүүдэд шинээр илрүүлсэн дурсгалын хэрэглэгдэхүүнд тулгуурлан байршил зүйн асуудлыг хөндөн авч үзэх боломжтой болсон юм.

Тал, хээрийн бүс нутгийн палеолитын дурсгал ихэвчлэн эртний нуур, голын сав газарт буюу усны ойр байрладаг. Чухамдаа усны эх үүсвэртэй ойр газраас баялаг олдвор бүхий томоохон дурсгал илрэх нь түгээмэл бөгөөд энэ нь хүн амьдрах таатай нөхцөл тухайн газарт бүрэлдсэн байсантай холбоотой.

Тал, хээрийн бүс нутгийн палеолитын зарим дурсгал алсын бараа сайн харагдах өндөрлөг газарт оршдог. Тухайлбал, Ачаат уулын энгэрийн нэлээд өндөрлөг дэвсэгт түүхий эдийн баялаг нөөцтэй газар чулуун зэвсгийн олдвор газрын хөрсөн дээр шигүү тархсан байх ба эндээс эргэн тойрныг сайтар харах боломжтой ажээ. Өөрөөр хэлбэл, алсын харууц сайн, түүхий эдийн нөөцтэй, өндөрлөг газарт эртний хүмүүс суурьшиж байсныг Ачаат уулын дурсгалаас харж болохоор байна.

Уулын өвөр биеийн наран ээвэр нөмөр газарт бусад үеийн дурсгалтай хамт палеолитын бууц, суурин байрлаж буй хэд хэдэн тохиолдол мэдэгдээд байна. Тухайлбал, Богд уулын суурин ар талаараа өндөр уулаар нөмөрлөсөн агаад зонхилогч буюу баруун хойд зүгийн салхинаас нөмөрлөсөн уулын бэлд оршдог. Байршил зүйн энэхүү хэв шинж Зараа уулын Оцон цохио, Зүүн шовхын сууринд мөн ажиглагдсан бөгөөд аль аль нь ар талаасаа нөмөрлөсөн цохио хадны өвөрт байрлана. Ийнхүү уулын хадан тогтоцтой ойролцоо байрлах нь нөмөр дулаанаас гадна чулуун зэвсэг хийх түүхий эдийн нөөцтэй давхар холбоотой юм.

Тал, хээрийн бүс нутгийн боржин чулуун цохио бүхий өвөрмөц тогтоцтой газруудад олон үеийн археологийн дурсгал байдаг. Дэлгэрхаан уул, Ширийн чулуу, Бударын чулуу, Их, Бага Нартын хад зэрэг газарт их төлөв неолитын баялаг олдвортой бууц суурин тааралдах боловч палеолитын хэв шинжийг илэрхийлсэн бэлдэц, цуулдас цөөн тооны үлдэц бүхий олдвортой бууцнууд тохиолдох нь бий. Газрын хөрсөн дээрх олдворын нягтаршил, хамрах хүрээ хүн урт хугацаанд суурьшаагүйг илтгэх боловч боржин чулуун цохио нь хүн далдлан ан ав хийх таатай орчин тул ийм газарт палеолитын үеийн анчин түүвэрлэгчдийн отог буудлын үлдэгдэл үлдэж хоцорсон байна.

Хөндөн үзэж буй бүс нутгийн палеолитын дурсгалын орших орчны нийтлэг хэв шинжид тулгуурлавал,

- Түүхий эдийн нөөцтэй харууц сайн өндөрлөг газарт
- Ихэнхдээ салхинаас нөмөрлөсөн уулын бэл, ханан хадны энгэрт
- Боржин цохио хадны орчимд хэмээн ангилан үзэх боломжтой юм.

Тал, хээрийн бүс нутгийн палеолитын дурсгалын байршил зүйн дээр дурдсан онцлог Монголын бусад газрын дурсгалтай адилсах тал буйг тэмдэглэх хэрэгтэй. Судлаач Г.Ангарагдөлгөөн Монгол орны палеолитын соёлт давхаргатай дурсгалын байршил зүйн асуудлыг хөндөн үзэхдээ орчны ерөнхий хоёр шинж буйг тэмдэглэсэн. Түүний 2-р ангилал буюу голоос зайдуу бөгөөд ар талаараа хадаар хүрээлүүлсэн нөмөр газарт байрласан [Ангарагдөлгөөн, 2020: 10] дурсгалуудтай Ачаат уул, Гурван овоот зэрэг газрын дурсгал төстэй буйг тэмдэглэх хэрэгтэй.

Палеолитын дурсгалын нэг үндсэн хэлбэр нь агуйн суурин юм. Гэвч одоогийн байдлаар тал, хээрийн бүс нутгаас агуйн дурсгал илрүүлж, судлан шинжилсэн зүйл байхгүй. Энэ нь агуйн суурин огт байхгүй гэсэн үг биш бөгөөд хятадын судлаачид Монгол Улсын хилийн шугамтай ойролцоо газраас дунд палеолитын төгсгөл, дээд палеолитын эхэн үед холбогдох хүн урт хугацаагаар амьдарсан дурсгалыг илрүүлэн, судалгааны үр дүнг нийтэлжээ [Feng li et al., 2018: 76-84]. Тиймээс цаашид агуйн мэдээллийг цуглуулах, судлах нь бүс нутгийн палеолитын судалгаанд сонирхолтой үр дүнд хүргэж мэдэх юм.

Палеолитын дурсгалын, байршил зүйн онцлог олдворын төрөл зүйлтэй харилцан хамааралтай нь ажиглагдаж байна. Тухайлбал, Богд уул, Ачаат уул, Зараа уулын Оцон цохио, Зүүн шовхын дурсгал түүхий эдийн нөөцтэй ойр оршдог тул цуулалтын

оромтой хагархай хэлтэрхий хөрсөн дээр олон байна. Түүнчлэн, дутуу засаад орхисон бэлдэц, цуулалтын оромтой түүхий эд, олон төрлийн үлдэц (Хүснэгт 1) түүхий эдийн тогтоцтой ойр байрлах эдгээр дурсгалаас олджээ.

Энэ байдал нь дээр дурдсан дурсгалууд палеолитын суурин-дархны газар болохыг илтгэж байгаа юм. Харин Хангай хад, Гурван овоот зэрэг түүхий эдгүй газарт олдвор, тэр дундаа анхдагч цуулалтыг илэрхийлэх эдлэл цөөн (Хүснэгт 1) бөгөөд чулуун зэвсэг хийсэн материалыг зөөвөрлөн авчирсан нь тодорхой байна.



Зураг 1. Ачаат уулын суурин. *1, 2 - таргил үлдэц*

Судалгааны хүрээнд авч үзэж буй Ачаат уул, Богд уул, Зараа уулын Оцон цохио, Зүүн шовх, Хангай хадны палеолитын дурсгалын цуглуулгад бэлдэц, үлдцийн төрлийн эдлэл 85 ш байна. Тэдгээр нь төрөл зүйлийн хувьд цуулалтын оромтой түүхий эд 11 ш (12.9%), бэлдэц 2 ш (2.3%), янз бүрийн үлдэц 72 ш (84.7%) хэмээн ангилагдана.

Тодорхой дэс дараалалгүй замбараагүй цуулалтын ул мөрийг агуулсан түүхий эд палеолитын янз бүрийн шатанд холбогдох суурин, тэр дундаа түүхий эдэд ойр орших дархны газруудад элбэг тааралддаг. Зарим нь түүхий эд болох чулуулгийг шалгаж цуулалт хийсэн байдаг бол зарим нь аль нэг тэгш талыг юм уу, өмнөх цуулалтын ормыг цохилтын талбай болгон ашиглах замаар чулууны гадаргуугийн янз бүрийн хэсэгт цуулалтууд гүйцэтгэсэн байдаг билээ.

Дурсгалуудын олдворын цуглуулгад буй анхдагч цуулалтыг илэрхийлэх эдлэлүүдээс үзэхэд, хамгийн эртнийх нь зах ирмэгээс төв рүү чиглэсэн цуулалт бүхий таргил үлдэц байх магадлалтай. Ийм төрлийн зассан оромтой таргил үлдэц одоогоор бидэнд буй хэрэглэгдэхүүн дотор 4 ш байна (үлдцийн 5.5%-ийг бүрдүүлнэ). Тэдгээр нь үлдцийн бусад төрөл зүйлтэй харьцуулахад том хэмжээтэй бөгөөд зах ирмэгээс нь төв рүү чиглүүлсэн цуулалтуудыг хийсэн ул мөртэй (Зураг 1. *1, 2*).

Таргил үлдцээс төв рүү чиглэсэн цуулалтаар ялтас авах арга ажиллагаа нэлээд эрт үед холбогдох магадлалтай. Ер нь энэ төрлийн үлдэц өргөн залтас цуулж авахад зориулагдсан бөгөөд залтасны зах ирмэгийг дахин засаж ирлэн хоёрдогч боловсруулалт хийдэг байжээ.

Хүснэгт 1. Анхдагч цуулалтын ангилалд хамаарах олдворын төрөл зүйл

Чулуун зэвсгийн олдвор	Ачаат уул		Богд уул		Зараа уулын Оцон цохио		Зараа уулын Зүүн шовх		Гурван овоот		Хангай хад		Нийт тоо
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Анхдагч цуулалт													
Цуулалтын оромтой түүхий эд	2	8	5	14.2	3	23.2	-	-	-	-	1	33.4	11
Бэлдэц	2	-	-	11.4	-	-	-	-	3	100	-	-	5
Леваллуагийн үлдэц	-	-	6	17.4	4	30.7	4	40	-	-	-	-	14
Таргил үлдэц	2	8	2	5.7	-	-	-	-	-	-	-	-	4
Цохилтын нэг талбайтай, зэрэгцээ цуулалт бүхий хавтгай үлдэц	3	12	4	11.4	6	46.1	6	60	-	-	2	66.6	21
Цохилтын хоёр талбайтай, цуулалтын нэг гадаргуутай үлдэц	4	16	1	2.8	-	-	-	-	-	-	-	-	5
Цохилтын нэг талбайтай, зэрэгцээ цуулалтын зарчимт үлдэц	8	32	11	31.4	-	-	-	-	-	-	-	-	19
Цохилтын олон талбайт үлдэц	3	12	-	-	-	-	-	-	-	-	-	-	3
Нийт	25	100	31	100	13	100	10	100	3	100	3	100	85

Таргил үлдэц Монгол Алтайн нуруу, Говь-Алтайн нуруу, Эртний нууруудын хөндий, Орхон голын сав, говийн бүс нутаг зэрэг манай орны байгаль газарзүйн янз бүрийн орчинд орших палеолитын соёлт давхаргатай болон ил сууринуудаас олджээ. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц, Олон нуур-1, 2, Баяннуур, Ховд аймгийн Ховд-1 сууринаас илрүүлсэн энэ төрлийн үлдцийг судлаачид цуулалтын ерөнхий арга барил, үндсэн хэв шинжид нь тулгуурлан мустьен үед хамааруулжээ. Харин Алтанцөгцийн цуглуулгад буй зарим таргил үлдцийг хожуу мустьен үед хамааруулан авч үзсэн байдаг [Деревянко и др., 1990: 211-229].

Баянхонгор аймгийн Байдрагийн голын 9-р суурин, Баян-Овоо сумын Нарийн голын 26б сууринаас таргил үлдэц цөөнгүй олдсон байна. Эдгээр суурины он цагийг судлаачид мустьен үе, хожуу мустье болон дээд палеолитын үед харьцуулсан судалгааны аргаар холбогдуулан авч үзжээ [Цэрэндагва нар., 2017: 53, 65, 208].

Таргил үлдэц дээд палеолитын үед ч ашиглагдаж байв. Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт малтсан Орхон-1 соёлт давхарга бүхий суурины малтлагын 1 болон 2-р талбайн 3 -р үеэс илэрч олдсон юм. Орхон-7 соёлт давхарга бүхий суурины 1-р малтлагын талбайн 3 болон 4-р үеэс илэрсэн бөгөөд эдгээрийн холбогдох он цагийг Орхон-7 суурины 3 болон 4-р үе 37400±580, Орхон-1 суурины 1-3 үеийг 29465±445 [Деревянко и др., 2010: 31-33, 60-61] хэмээн үзсэн.

Эдгээрээс үзэхэд, төв рүү чиглэсэн цуулалт бүхий таргил үлдэц нь дунд палеолитын үед төдийгүй дээд палеолитын эхэн үед ашиглагдаж байжээ. Харин тал хээрийн бүс нутгийн хувьд энэ төрлийн үлдэц чухам аль үед нь холбогдох вэ? гэдэг асуулт гарах нь дамжиггүй. Зараа уулын Оцон цохио, Зүүн шовх зэрэг газарт малтлага судалгаа хийж үнэмлэхүй он цагийг тогтоосон дурсгалуудад энэ төрлийн үлдэц тэмдэглэгдээгүй. Мөн Хэрлэнбаян-Улаан уулын Ханзатын дурсгалд таргил үлдэц мэдэгдэхгүй байна. Эдгээрээс үзэхэд, тал, хээрийн бүс нутагт дээд палеолитын эхэн үед таргил үлдэц ашиглагдахгүй болсон байх магадлалтай. Тиймээс Ачаат уул, Богд уулаас илрүүлсэн дээрх таргил үлдцийг дээд палеолитын эхлэл, эсвэл дунд палеолитын төгсгөл үед холбон үзэх боломжтой ажээ.

Тал, хээрийн бүс нутгийн палеолитын бууц суурин леваллуагийн чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга харьцангуй хожуу үеийг хүртэл ашиглагдсаар байсан нь сонирхолтой юм. Леваллуагийн арга барил нь хоёрдогч бэлдэц цуулдсаар зэвсэг хийх явдлыг анхдагч цуулалтад шилжүүлсэн явдал юм [Цэрэндагва, 2017: 117] юм. Өөрөөр хэлбэл, үлдцээс цуулж авсан ялтас, залтсыг дахин засалгүй ашигладаг ажээ. Судлаачид леваллуагийн арга барил ашелийн үед үүссэн бөгөөд мустьен үед хөгжингүй шатандаа хүрсэн гэж үздэг.

Судалгааны хүрээнд авч үзэж буй дурсгалуудаас цуглуулсан анхдагч цуулалтыг илэрхийлэх эдлэлийн дотор леваллуагийн үлдэц 14 ш (19.4%) буюу нэлээд өндөр үзүүлэлттэй байна. Эдгээрийн хамгийн олон нь Богд уулаас (6 ш), Зараа уулын Оцон цохио, Зүүн шовхоос тус бүр 4 ш олджээ.

Эдгээр үлдцийг бэлтгэхдээ бүхэлдээ үзүүр мэс буюу ганц гурвалжин цуулдас авахад чиглэгдсэн байна. Ийм төрлийн эдлэл Алтайн нурууны баруун хойд хэсгээс эхлэн зүүн урагш Алтайн нурууны салбар уулс, Хэнтийн нурууны зүүн ба зүүн урд талын дурсгалуудаас илэрдэг. Монголын палеолитын дурсгал дахь леваллуагийн үлдцийг Е.П. Рыбин, А.М. Хаценович нар 4 төрөл [Rybin, Khatsenovich, 2020: 130-132], Д.Базаргүр 5 төрөлд [Базаргүр, 2015: 3-4] ангилсан байдаг.

Зараа уулын Оцон цохионоос илрүүлсэн леваллуагийн үлдцийн 1 нь жижиг (Зураг 2. *5*), бусад нь дундаж хэмжээтэй бөгөөд бүгд ар тал руугаа налсан нарийн, бөмбөгөр цохилтын талбайтай ажээ (Зураг 2. *2, 3, 4*) [Odsuren et al., 2023: 10]. Харин Богд уулын ил сууринаас түүвэрлэсэн леваллуагийн үлдэц гурвалжиндуу хэлбэртэй, гүдгэр цохилтын талбайтай. Цуулалтын гадаргууг хоёр талаас хөндлөн цуулах аргаар төвгөр болгон зассан ба ар талыг хавтгайлж зассан ул мөртэй (Зураг 2. *1*). Зарим эдлэлийн цуулалтын ул мөр элэгдлийн улмаас мэдэгдэх төдий болсон байна.

Одоо мэдэгдэж буйгаар хожуу леваллуагийн үйлдвэрлэлийн арга барилыг илэрхийлэх он цаг нь тогтоогдсон дурсгалын нэг бол Говь-Алтайн нурууны Чихэн агуйн 4-р давхарга юм [Derevainko et al., 2004: 217-222]. Энэ давхаргыг судлаачид дээд палеолитын эхэн, дунд, төгсгөл шатанд холбогдуулан үздэг бөгөөд олдворын бүрдлийн үлдэц хэлбэрийн эдлэлүүдийн дотор леваллуагийн хэв шинжит эдлэл давамгайлдаг

[Цэрэндагва, Деревянко, Цэвээндорж, 2017: 214]. Агуйн ул шалны дээхэн талын 37-р галын ормын шатсан модонд хийсэн радиокарбоны шинжилгээгээр 27432±872 (AA-26580) жилийн өмнөх үед холбогдох он цагийн хамаарал гарсан [Derevianko et al., 2015: 22] бол ойролцоо орших Чихэн-2 дурсгалын 3-р давхаргаас леваллуагийн үлдэц, үзүүр мэс олон гарсан нь Чихэн агуйн плейстоцены давхаргын олдвортой адилсаж байгаа юм.



Зураг 2. *Богд уулын суурин. 1 – леваллуагийн үлдэц*. Зараа уулын Оцон цохионы суурин. *2 – 5 леваллуагийн үлдэц*

Дээр дурдсан Чихэн агуй, Чихэн 2 болоод Арц Богдын нурууны зүүн хэсэг, Цахиуртын хөндийн сулавтар элэгдэлтэй олдворын бүлэгт буй леваллуагийн хожуу үеийн чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга ажиллагааг илтгэх эдлэлүүд дээд палеолитын эхэн үед гарч ирсэн зэрэгцээ цуулалтын арга барилт үлдцүүдтэй олдворын нэг бүрдэлд хамаардгийг судлаачид тэмдэглэжээ [Odsuren et al., 2023: 18-21].

Үлдцийн дараагийн төрөл бол цохилтын нэг болон хоёр талбайтай, зэрэгцээ цуулалтат үлдэц юм. Зэрэгцээ цуулалтын арга ажиллагаа 45 мянга орчим жилийн өмнөөс чулуун зэвсгийн үйлдвэрлэлд нэвтэрчээ. Гол онцлог нь нэг үлдцээс авах бүтээгдэхүүн буюу ялтасны тоог нэмэгдүүлсэн явдал юм.

Судалгааны хүрээнд авч үзэж буй дурсгалын үлдцийн дийлэнхийг энэ төрлийн эдлэл бүрдүүлнэ. Тэдгээрт арагш налуу цохилтын талбай бэлтгэсэн агаад цөөн тохиолдолд талбайг тэгшилж зассан, эсвэл чулууны тэгш гадаргыг ашиглажээ. Харин цуулалтын гадаргууд олон удаагийн зэрэгцээ цуулалт хийх зарчмаар урт богино ялтас авсан ул мөр мэдэгдэнэ (Зураг 3. *1-5*). Эсрэг тал нь дийлэнх тохиолдолд чулууны өнгөн бүрхүүлээ хадгалсан байдаг бол цөөн тохиолдолд хөндлөн цуулалт хийх аргаар зассан байх ажээ. Эдгээрээс сонирхол татахуйц нэг үлдэц байгаа нь цохилтын хоёр талбайтай цуулалтын нэг гадаргуутай уртавтар зууван эдлэл юм. Цуулалтын гадаргууд зэрэгцээ цуулалтын ором байх бол эсрэг талыг шаантаг үлдцийн адил хоёр талаас нь хөндлөн цуулалтаар долгиотсон хурц ирмэг үүсгэжээ. Энэ төрлийн үлдцүүд манай орны дээд палеолитын эхэн шатанд хамаарах Их Төлбөрийн голын хөндийн соёлт давхаргатай дурсгалуудын 4, 5-р давхарга

[Gladyshev et al., 2012: 38-39] болон Цагаан Туруутын голын хөндийн түүвэр олдворуудын дотор олон бий [Bolorbat et al., 2023: 495-497]

Тал, хээрийн бүс нутгийн дээд палеолитын эхэн үед холбогдох дурсгалтай нэг цаг үед холбогдох Монгол орны бусад томоохон дурсгалуудад зэрэгцээ цуулалтын арга технологи илүүтэй давамгайлж, харин леваллуагийн арга ихээхэн бүдгэрсэн нь ажиглагддаг. Харин энэ үед бидний авч үзэж буй хээрийн бүс нутагт зэрэгцээ цуулалт болон леваллуагийн уламжлал дээд палеолитын дунд үед хүртэл зэрэгцэн ашиглагдаж байжээ. Энэ нь Монгол орны өргөн уудам нутагт амьдарч байсан эртний хүмүүсийн чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга, соёлын хувьд ялгаатай байдлыг илтгэх баримт байж мэднэ.



Зураг 3. Зараа уулын Оцон цохионы суурин. 1, 2 – *зэрэгцээ цуулалтат үлдэц.*
Ачаат уулын суурин. 3, 4 зэрэгцээ цуулалтат үлдэц.

Энэ талаар зарим судлаачид өмнө анхааран үзэж эдлэлийн хэв шинж, цуулалтын арга барилаар бусад бүс нутгийн хүрээнд хийгдсэн судалгаатай харьцуулж тодорхойлсон байдаг. Тухайлбал, Зараа уулын Оцон цохио, Зүүн шовхын дурсгалаас илэрсэн эдлэлүүдийг Умард Монгол Сэлэнгэ мөрний дунд урсгалын Төлбөр-4, Төлбөр-15, Төлбөр-16 ба Төв Монголын нутаг дахь Цацын эрэг-2 зэрэг он цаг тодорхой тогтоодсон дээд палеолитын эхэн үед хамаатах дурсгалуудтай харьцуулан дүгнэжээ [Odsuren et al., 2023: 10].

Палеолитын бууц суурингийн чулуун зэвсэг үйлдвэрлэлийн анхдагч цуулалтын арга ажиллагааг тодруулахад, цуулдасны үйлдвэрлэлд хамаарах ба ирлэж хоёрдогч боловсруулалт хийгээгүй залтас, ялтас чухал хэрэглэгдэхүүн болдог. Гэвч бидний авч үзэж буй дурсгалуудын ихэнх ил суурин бөгөөд чулуун зэвсгийн цуглуулгад залтас, ялтас цөөн байна. Ер нь залтас, ялтасны тоон үзүүлэлт тодорхой талбайд хийсэн малтлага дээр илүү тодорхой харьцаатай гардаг билээ. Хээрийн бүс нутгийн дээд палеолитын дурсгалуудын хувьд дээд палеолитын эхэн үеэс ялтас цуулах арга ажиллагаа чулуун зэвсгийн үйлдвэрлэлд нэвтэрсэн бөгөөд ялтаснууд нь тэгш бус хэмтэй, бөмбөгөр цохилтын талбайн ормыг хадгалсан байдаг. Ил суурингаас бүтэн ялтас цөөн олддог зүй тогтол бидний авч үзэж буй дурсгалуудад ч мөн ажиглагдсан.

Хэлэлцүүлэг

Судалгааны хүрээнд авч үзсэн ихэнх дурсгал дунд палеолитын төгсгөл, дээд палеолитын эхэн үед холбогдох юм. Тиймээс чулуун зэвсгийн үйлдвэрлэлд төв рүү чиглэсэн, леваллуагийн,

зэрэгцээ цуулалтын зэрэг олон арга ашиглагдаж байсан нь тодорхой байна. Ил суурингийн нөхцөлд чулуун зэвсэг үйлдвэрлэлийн анхдагч цуулалтыг илэрхийлэх дээрх аргууд тодорхой залгамж холбоотой, ар араасаа гарч ирсэн үү? Эсвэл зэрэгцэн оршиж байсан уу гэдэг нь сонирхолтой байна. Нөгөө талаар тал, хээрийн бүс нутагт холбогдох он цагийн асуудлыг нарийвчлан тогтоосон дурсгал цөөн буй нь дээрх асуултад хариулт өгөхөд саад болж байгаа юм.

Бидний хувьд таргил ба леваллуагийн хэв шинжит үлдцүүд энэ бүс нутгийн дурсгалуудад нэлээд түгээмэл тааралдаж буй нь анхаарал татаж байгаа бөгөөд дээд палеолитын эхэн үед зэрэгцээ цуулалтын үйлдвэрлэлтэй зэрэгцэн оршиж байжээ. Судалгаа харьцангуй сайн хийсэн Монголын умард хэсэг буюу Сэлэнгэ мөрний сав дагуух соёлт давхаргатай суурингуудаас ялгарах гол онцлог болж байна. Харин ямар учраас чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн хувьд ялгаатай ойролцоо цаг үед холбогдох дурсгал буй нь эртний хүний нүүдэл, суурьшлын зам чиглэлтэй холбоотой бололтой.

Судалгааны хүрээнд авч үзсэн палеолитын дурсгал, тэр дундаа леваллуагийн цуулалтын арга барил говийн өмнөд хэсэг хийгээд БНХАУ-ын умард талын дурсгалуудтай үйлдвэрлэлийн арга ажиллагааны хувьд ихээхэн төстэй байгаа нь цаашид палеолитын соёлын бүсчлэлийн асуудлыг хөндөх боломж бүрдүүлж магадгүй юм.

Дээд палеолитын эхэн үеэс анчин түүвэрлэгчид зэрэгцээ цуулалтын аргаар ялтас цуулж авах болжээ. Өнөөгийн тал хээрийн бүс нутгийн дурсгалуудад энэ арга мөн ажиглагддаг боловч зарим үлдэц ихээхэн том бахим байгаа нь сонирхол татна. Хэдийгээр урт цуулдас буюу бүтээгдэхүүн авахаар төлөвлөсөн байж болох ч түүхий эдийн онцлогтой холбоотой байхыг үгүйсгэхгүй. Тал, хээрийн бүс нутгийн ихэнх дурсгал цахиурлаг чулуу, хайрга мэтийн нарийн ширхэгтэй бус, зарим дурсгалд кварцаар зэвсэг хийсэн тохиолдол ч бүртгэгдсэн билээ.

Тал, хээрийн бүс нутгийн палеолитын дурсгалаас үзэхэд, чулуун зэвсэг үйлдвэрлэлийн анхдагч цуулалтын арга ажиллагаагаар Умард монголоос нэлээд ялгаатай нь харагдах бөгөөд цаашид нүүдлийн зам чиглэлтэй холбон дэлгэрэнгүй мэдээлэл бий болгох хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Дүгнэлт

Монгол орны нутаг дэвсгэрийн үлэмж хэсгийг эзлэн орших тал хээрийн бүс нутгаас сүүлийн жилүүдэд илрүүлсэн палеолитын сууринууд нь чулуун зэвсэг үйлдвэрлэлийн аргын хувьд леваллуагийн ба зэрэгцээ цуулалт давамгайлж буй нь тодорхой байна. Ялангуяа, леваллуагийн арга харьцангуй хожуу үе хүртэл буюу дээд палеолитын дунд үе хүртэл ашиглагдаж байсан нь гол онцлог юм. Хэдийгээр дээд палеолитын эхэн үеэс зэрэгцээ цуулалтын арга чулуун зэвсгийн үйлдвэрлэлд нэвтэрч, урт болон богино ялтас цуулж авах болсон нь бусад бүс нутгийн нэг цаг үед холбогдох дурсгалтай ижил байгаа ч леваллуагийн арга зэрэгцэн оршиж байжээ. Үлдцээс цуулж авсан ялтсын дийлэнх тэгш бус хэмтэй буй нь анхаарал татдаг. Энэ нь түүхий эдийн онцлогтой холбоотой бололтой.

Ийнхүү тал хээрийн бүс нутгийн палеолитын дурсгалын анхдагч цуулалтын арга бусад бүс нутгаас тодорхой ялгаатай буй нь тухайн дурсгалыг үлдээгчдийн нүүдлийн зам чиглэлтэй холбоотой хэмээн үзэж байна. Дээд палеолитын дундаас хойших үед жижиг ялтас цуулж авах арга чулуун зэвсгийн үйлдвэрлэлд давамгайлах хандлагатай болсон бөгөөд бусад бүс нутгаас ялгарах онцлог мэдэгдэхгүй болжээ.

Ном зүй

Ангарагдөлгөөн, 2020 – Г.Ангарагдөлгөөн. Монгол орны хуучин чулуун зэвсгийн соёлт давхаргатай дурсгалын байршил зүйн асуудалд. // Studia archaeological. Tom. XXXIX, fasc. 1. УБ., 2020. Тал 5-126.

Базаргүр, 2015 - Д.Базаргүр. Монголын чулуун зэвсгийн дурсгалууд дахь леваллуагийн арга ба тархалт. // Studia Archaeologicaв Tom. XXXV. Fasc. 1. Улаанбаатар. 2015. Тал 1-14.

Болорбат, Одсүрэн, 2021 – Ц. Болорбат, Д. Одсүрэн. Уулбаян сумын нутгаас шинээр илрүүлсэн чулуун зэвсгийн дурсгалын он цагийн асуудалд. Studia Archaeologica. Tom. XL, Fasc. 2. Улаанбаатар. 2021. Тал 12-21.

Болорбат нар., 2022 – Ц. Болорбат, Д. Одсүрэн, Б. Лхагвасүрэн, Э. Донойдугар. Богд уулын палеолитын дурсгал. Studia Archaeologica. Tom. XLI, Fasc. 2. Улаанбаатар. 2022. Тал 12-19. https://doi.org/10.5564/sa.v41i1.2479.

Деревянко и др., 1990 – А.П.Деревянко., Д.Дорж., Р.С.Васильевский., В.Е.Ларичев., В.Т.Петрин., Е.В.Девяткин., Е.М.Малаева. Каменный век Монголии: Палеолит и неолит Монгольского Алтая. Новосибирск: Наука. Сиб. от-ние. 1990. - 646 стр.

Деревянко и др., 2010 – А.П.Деревянко, А.В.Кандыба, В.Т.Петрин, Палеолит Орхона. Новосибирск. 2010. - 381 стр.

Дорж, Цэвээндорж, 1978 – *Д.Дорж, Д.Цэвээндорж. Монголын палеолит. Улаанбаатар. - 156 тал.*

Цогтбаатар, Пүрэвжал, 2014 – Б.Цогтбаатар, Х.Пүрэвжал. Ачаат уулын чулуун зэвсгийн суурин. Studia Archaeologica. Tom. XXXIV, Fasc. 3. Улаанбаатар. 2014. Тал 15-25.

Цэрэндагва, 2017 – Я.Цэрэндагва. Палеолит судлалын үндэс. Улаанбаатар. 2017. - 173 тал.

Цэрэндагва нар, 2017 – Я.Цэрэндагва, А.П.Деревянко, Д.Цэвээндорж. Баянхонгор аймгийн хуучин чулуун зэвсгийн дурсгалууд. УБ., 2017. - 406 тал.

Bolorbat et al., 2023 - Tsedendorj Bolorbat, Dashzeveg Bazargur, Guunii Lkhundev, Batsuuri Ankhbayar, Adyasuren Altanbagana, Tsend Amgalantugs, Gonchig Batbold, Cao Jian'en, Song Guodong, Cao Peng, Cai Xi. The northern dispersal route: new evidence of Upper Paleolithic human behavior from the Tsagaan Turuut River Valley, central Mongolia. // Acta Anthropologica Sinica. Vol. 42. Issue 4. Pp 488-502. https://doi.org/10.16359/j.1000-3193/AAS.2022.00076.

Derevainko et al., 2004 – A.P.Derevainko., P.J.Brantingham., J.W.Olsen, D.Tseveendorj. Initial Upper Paleolithic blade industries from North-Central Gobi Desert, Mongolia. // The Early upper Paleolithic beyond Western Europe/ Ed. by P. Jeffrey Brantingham, Steven L Kuhn, Kristopher W. Kerry. Berkeley; Los Angeles; London: University of California Press. 2004. Pp 207-222.

Derevyanko et al., 2015 – A.P. Derevyanko, S.V. Markin., S.A. Gladyshev., J.W.Olsen. Early Upper Paleolithic of the Gobi Altai Region in Mongolia (Based on Materials from the Chicken-2 site). // Archaeology, Ethnology and Anthropology of Eurasia. 2015. №3 (43). Pp 17-41. https://doi.org/10.1016/j.aeae.2015.11.004

Feng et al., 2018 - Fen Li., Kuhn S. L., Chen F., Wang C., Ge J., Wang X., Yun T., Gao X. The easternmost Paleolithic Mousterian from Jinistai Cave, North China. // Journal of human evolution. Vol 114. Pp 76-84. https://doi.org/10.1016/j.jhevol.2017.10.004.

Gladyshev et al., 2012 – S.A. Gladyshev., J.W. Olsen., A.V. Tabarev., J.T. Jull. The Upper Paleolithic of Mongolia: recent finds and new perspectives. // Quaternary international. Vol 281. Pp 36-46. https://doi.org/10.1016/j.quaint.2012.01.032.

Odsuren et al., 2020 – D.Odsuren, L.Janz, William Fox, D.Bukhchuluun. Otson Tsokhio New Evidence for Early Upper Palaeolithic habitation and possible ritual behaviour in eastern Mongolia. Journal of Paleolithic Archaeology (2023) 6:10. doi.org/10.1007/s41982-023-00139-x.

Rybin, Khatsenovich, 2020 – E.P.Rybin., A.M.Khatsenovich. Middle and Upper Palaelithic Levallois technology in eastern Central Asia. // Quaternary International. Vol. 535. Pp 117-138. https://doi.org/10.1016/j.quaint.2018.10.042.

Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.
See: http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/